



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2021-02-11 № 10

Асуулга тавих тухай

Улсын Их Хурлаас 2017 онд баталсан Малын генетик нөөцийн тухай хуулиар малын үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хийх, бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хяналт тавих, улмаар урт хугацаандаа монгол малын тэсвэрт чанар, ашиг шим нэмэгдэж, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар сайжрах, малчдын амьжиргаа орлого дээшлэх, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний импортыг орлож, экспортыг нэмэгдүүлэх эрх зүйн таатай нөхцөл бүрдсэн.

Гэсэн хэдий ч уг хуулийн биелэлт, хэрэгжүүлэх талаар санал санаачилга хангалтгүй, шаардлагатай хөрөнгө, санхүүжилтийг Засгийн газраас шийдвэрлэлгүй орхигдуулж ирсэн гэж үзэж байгаа тул хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дугаар зүйлийн 39.1.1-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуудлын хүрээнд асуулга тавьж байна. Үүнд:

1. Сүүний хангамжийг нэмэгдүүлэх, сүүний чиглэлийн өндөр ашиг шимтэй малын тоо толгойг нэмэгдүүлэх, үнийг тогтворжуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн талаар (аймаг, он тус бүрээр);
2. Малыг бордож, жилийн турш иргэдийг шинэ махаар хангахаар авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн талаар (аймаг, сар тус бүрээр);
3. Байгалийн тэжээлийг орлох таримал тэжээл тариалах, ногоон тэжээлийн нэр төрөл, чанар, хангалтыг нэмэгдүүлэх, тэжээлийн үнийг тогтворжуулах талаар хэрэгжүүлсэн ажлын үр дүн, үзүүлсэн дэмжлэгийн талаар (аймаг, он тус бүрээр);
4. Үүлдэр угсаа, ашиг шим өндөр үзүүлэлт бүхий хээлтүүлэгч мал болон цөм сүргийг сумдад бий болгосон талаар хийсэн ажил, үзүүлсэн дэмжлэг, санхүүжилтийн талаар (аймаг, он тус бүрээр);
5. Малын ашиг шим, үүлдэрлэг байдлыг сайжруулах чиглэлээр малын үржүүлэг, технологийн нэгжүүдийн хийсэн үзлэг, мал ялган тэмдэглэх болон ангилалтын ажил, нэгжүүдэд үзүүлсэн дэмжлэг, санхүүжилтийн талаар (аймаг, он тус бүрээр);
6. Малын удам гарвал, үүлдэрлэг байдал, ашиг шимийн түвшинг улсын хэмжээнд тодорхойлох, төлөв байдлыг үнэлэх ажил хэдэн хувьтай хийгдсэн талаар (аймаг, он тус бүрээр);

2020000101



7. Мал зүйч мэргэжилтнийг мэргэшүүлэх, боловсон хүчний хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх, сум, дүүргийн Хөдөө аж ахуйн тасгийн батлагдсан орон тоонд мэргэжлийн мал зүйч ажиллуулах, цалингийн шатлалыг нэмэгдүүлэх, улсын байцаагчийн эрх олгох, мал зүйчдийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийгдсэн ажлын талаар;

8. Найдвартай эрүүл мал, хүнстэй болох, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортод чөлөөтэй нийлүүлэх үндэс болсон малыг бүртгэлд хамруулах, ээмэгжүүлэх, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх чиглэлээр хийгдсэн ажлын талаар (хамруулсан болон хамруулах малын тоог он тус бүрээр);

9. Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад зориулан жил бүр төсөвт тусгасан хөрөнгө, санхүүжилт болон генийн сан бүрдүүлэх, хадгалах, хамгаалах чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй төсөл, санхүүжилтийн талаар (он тус бүрээр);

10. Малын генетик нөөцийн тухай хуулийг дагалдан гарах эрх зүйн акт, заавар, аргачлал, стандарт, нормативыг батлан, хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар;

11. Хуулийн биелэлтийг хангуулах талаар цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бодлого, арга хэмжээний талаар.

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тулгуур салбар болсон мал аж ахуйн салбарын гол хууль болох Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах асуудалд анхаарал хандуулан ажиллах, улмаар асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3, 39.4-т тус тус заасны дагуу ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Г.ТЭМҮҮЛЭН

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Л.МӨНХБААТАР